# “БАГАЧУУД ХҮНС” ОНӨААТҮГ-ЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 04 — Улаанбаатар хот

| Д/д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Төсөв /мян.төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилго 1. Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлнэ:** Нийслэлийн хөгжлийн төлөвлөгөө 1, 44, Нийслэлийн Засаг Дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2.3.5.2, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 2.5.1 | | | | | | | |
| **Зорилт 1.** Нийслэлийн хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөний 1 дэх заалт. Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | | | | | | | |
| 1.1.1. | Байгууллагын нийт ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт жилд 2 удаа хамруулна. | 1,360.0 | Нийт ажилчдын тоо | 0 | 20 | 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт ажилчдыг Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төвд эрүүл мэндийн үзлэгт 2 удаа хамруулахад 2,192,000.00 төгрөгийг зарцуулсан байна. | 100% |
| 1.1.2. | Байгууллагын нийт ажилчдыг урьдчилан сэргийлэх эрт илрүүлэгийн үзлэг шинжилгээ, оношлогоонд бүрэн хамруулж, эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулна. | 6,000.0 | Эрт илрүүлэгт хамрагдсан хүний тоо | 0 | 20 | Байгууллагын нийт ажилчдыг урьдчилан сэргийлэх эрт илрүүлэгийн үзлэг шинжилгээ, оношлогоонд бүрэн хамруулж, 6,460,000.00 төгрөгийг зарцуулсан. | 100% |
| 1.1.3. | Байгууллагын контор, махны болон хуурай хүнсний агуулахууд, хүнсний зориулалттай түгээлтийн автомашинуудыг ариутгах, халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулна. | 2,500.0 | Ариутгал хийгдсэн тоо | 3 | 4 | “САН ХИМИ” ХХК-тай гэрээ байгуулсаны дагуу 2024 оны жилийн эцсийн байдлаар оффис, махны болон хуурай хүнсний агуулах, хүнсний зориулалттай 3 автомашины халдваргүйжүүлэлт, ариутгал халдваргүйтгэл 4 удаа хийлгэхдээ онцлог бүрт тохирсон лабораторийн шинжилгээгээр баталгаажсан ариутгалын бодис хэрэглэн ахуйн шавьж, мэрэгч | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | устгал халдваргүйтгэл хийсэн бүртгэл хөтлөн ажиллаж нийт 1,155,000 төгрөг зарцуулсан байна. | |
| 1.1.4. | Байгууллагын гадна, доторх талбайн их цэвэрлэгээг хийнэ. | - | Цэвэрлэгээ хийсэн тоо | 24 | 48 | Хүнсний агуулахад 7 хоног бүрийн Мягмар, Баасан гарагт тогтмол цэвэрлэгээ хийдэг ба сард 1 удаа гадна талбайн цэвэрлэгээг хийж ажиллалаа. Нийт хүнсний агуулахад 80 удаа, гадна талбайн цэвэрлэгээг 12 удаа хийж ажиллалаа. | 100% |
| 1.1.5. | Ажилчдын нэг удаагийн халдвар хамгаалльн хэрэгсэл, эмийн сан, гар ариутгагч, амны хаалтаар тогтмол хангаж, халдвар хамгаалльн дэглэмийг чанд мөрдөн ажиллана. | 1,500.0 | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Түгээлтэнд явж буй ажилчид болон оффисын ажилчдад маск, гар ариутгагчаар бүрэн ханган ажилладаг. Оффисс болон түгээлтийн автомашинд эмийн сан байдаг бөгөөд өглөө ажил эхлэхээс өмнө эмнэлгийн анхан шатны хяналт тавьж халдвар хамгаалльн дэглэмийг чанд мөрдөн маск, улавчаа тогтмол хэрэглэн ажиллаж байна. Түгээлтийн ажилчдын ажлын бээлийнд 1,704,100.00 зарцуулсан байна. | 100% |
| **Зорилт 2.** Нийслэлийн хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөний 44 дэх заалт. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол, хүнсний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, дотоод хяналтыг сайжруулна. | | | | | | | |
| 1.2.1. | Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн цэцэрлэг, сургуулиудад нийлүүлэх хүнсний бараа, бүтээгдэхүүний онлайн захиалгыг боловсронгуй болгож, захиалгын тоог нэмэгдүүлнэ. | 8,000.0 | 7 хоногийн захиалгын тоо | 2 | 2 | Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн цэцэрлэг, сургуулиудад нийлүүлэх хүнсний бараа, бүтээгдэхүүний онлайн захиалгын цэсийг тогтмол шинэчлэн, сургууль, цэцэрлэг онлайнаар захиалгаа өгөх талаар 1 удаа сургалт орсноор онлайнаар захиалгаа өгөх цэцэрлэг, сургуулийн тоо өссөн. | 100% |
| 1.2.2. | Хүнсний бүтээгдэхүүний чанар, хадгалалт, түгээлтэд хийх дотоод хяналтыг чанаржуулна. | - | Хяналт, шалгалт хийсэн тоо | 2 | 4 | Хүнсний бүтээгдэхүүний чанар хадгалалт, түгээлтэд 3 үе шаттай дотоод хяналт шалгалтыг зохион байгуулсан.<br>1.Байгууллагынхаа хуурай хүнс болон махны агуулахад<br>2.Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд<br>3.Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн 43 цэцэрлэг, 7 сургуулийн агуулах, бараа бүтээгдэхүүний хадгалалтад хяналт тавьж сэтгэл ханамжийн судалгаа авч ажилласан. Хяналт шалгалтаар 5 алдаа дутагдлыг илрүүлэн цаашид хэрхэн сайжруулах талаар зөвлөмж бэлтгэн хүргүүлж зөрчлийг арилгуулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| ЗОРИЛТ 2. Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжинэ. НЗДҮАХ 3.1.4.5 | | | | | | | |
| 2.2.1 | 2023 оны нийт худалдан авалтын үнийн дүнгийн 50-иас дээш хувьд дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн худалдан авах | Төсөв шаардахгүй | Нийт худалдан авалт | 5 | 5 | 2024 оны жилийн эцсийн байдлаар үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн нийт худалдан авалтын нэр төрлөөр 25 хувь, үнийн дүнгээр 67.5 хувиас дээш хувийг эзэлж байна. | 85% |
| **Зорилт 3.** Нийслэлийн хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөний 281 дэх заалт. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тарьц суулгацын нөөцийг бүрдүүлнэ. | | | | | | | |
| 1.3.1. | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарина. | 150,0.0 | тоо | 2 | 2 | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн “Ногоон хот-Иргэний оролцоо” хаврын мод тарих аянд хуваарийн дагуу 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо, Ар гүнт “Инчон мөрөөдлийн төгөл”-д өмнө нь тарьсан 217 ширхэг шинэс модны арчилгаа, усалгаанд анхаарч, 40 ширхэг шинэс мод нэмж тарьж 09 дүгээр сард тарьсан нийт модоо эргэн тойрч арчлан ажилласан. | 100% |
| **Зорилго 2. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 2.1. | УИХ, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Нийслэлийн засаг даргын захирамж, дээд газрын үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, мөрдөж ажиллана. | - | Тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Засгийн газрын тогтоол, Нийслэлийн онцгой комиссын шийдвэр, Нийслэлийн засаг даргын захирамж, нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс өгсөн 6 үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллаж, биелэлтийг заасан хугацаанд нь хүргүүлж ажилласан. | 100% |
| 2.2. | Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг хамгаалж, эд хөрөнгийн үзлэг тооллогыг явуулна. | - | Эд хөрөнгийн тооллогын бүртгэлийн тоо | 2 | 2 | 2024 оны эхний хагас жилийн байдлаар хөрөнгийн үзлэг тооллогыг байгууллагын захирлын тушаалаар томилогдсон ажилчид хийсэн бөгөөд эхний хагас жилд актлаж, устгах хөрөнгө байхгүй.<br>2024 оны жилийн эцсийн тооллогыг 2024 оны 12 сарын 15-ны өдөр захирлын тушаал гарган тоолохоор төлөвлөн ажиллаж байна. | 100% |
| 2.3. | Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, төсөв, санхүүгийн | - | Санхүүгийн сахилга батын | 100 | 100 | 2024 оны жилийн эцсийн байдлаар дараах зардлуудыг хэмнэн ажилласан байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сахилга батыг чанд мөрдөж, үргүй зардлыг хэмнэнэ. | | хэрэгжилтийн хувь | | | - Дотоод албан томилолтын зардалд 9,000,000.00 сая төгрөг төсөвлөснөөс улс орон даяар хэрэгжиж байгаа шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 1 ажилтан хөдөө орон нутагт ажиллаж байгаатай холбогдуулан 5,760,000.00 мянган төгрөгийн зардал гарган ажилласан. Сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээнд цахим хэлбэрээр оролцсон ба байгууллага дээрх сургалтыг өөрийн нөөц бололцоондоо тулгуурлан ямар нэгэн зардал гаргалгүйгээр зохион байгуулж ажилласан.<br>- Цалингийн зардал нь 530,777.5 мянган төгрөг төлөвлөсөнөөс 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 357,700.98 мянган төгрөг буюу 183,411.93 мянган төгрөгийн хэмнэлттэй ажиллаж байна.<br>- Гэрэл цахилгааны зардлыг 63,816.00 мянган төгрөг төсөвлөснөөс гүйцэтгэлээр 39,746.62 мянган төгрөг буюу 24,069.38 мянган төгрөгийн хэмнэлтийг гарган ажиллалаа.<br>- Тээвэр шатахууны зардалд 20,420.00 мянган төгрөг төсөвлөснөөс 15,200.00 мянган төгрөгийг зарцуулж, 12 сарын 04-ний өдрийн байдлаар тухайн зардлыг 5,220,00.00 мянган төгрөгийн урьдчилсан гүйцэтгэлтэй хэмнэлт гарган ажилласан. | |
| 2.4. | Архив, албан хэрэг хөтлөлтийг холбогдох заавар, журмын дагуу хөтөлж, тайлан, мэдээг хугацаанд нь хүргүүлж ажиллана. | - | хувь | 100 | 100 | 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар нийт 100 албан бичиг ирснээс хариутай бичиг 34, хариугүй 66 бичгийг хугацаанд нь шийдвэрлэж, 108 албан бичиг явуулсан байна. Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 1 албан бичиг байгаа болно. | 100% |
| 2.5. | Архивт нөхөн бүрдүүлэлт хийж, хүлээн авсан баримт бичгийг төрөлжүүлэн бүртгэнэ. | 3,500.0 | Архивын нөхөн бүрдүүлэлтийн хувь | 100 | 100 | Төрийн архивт 2023 онд нөхөн бүрдүүлэлт хийж ажилласан. Байгууллагын архивт батлагдсан хуваарийн дагуу ажилчдаас нөхөн бүрдүүлэлтийг хийн байнга, түр 70 жилээр ангилан хүлээн авсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.6. | Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг тухай бүр шинэчлэх; | - | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Байгууллагын дотоод хяналтын багийн бүрэлдэхүүн ажиллах журам, ажилчдын аюулгүй ажиллагааны журам, эрүүл ахуйн тухай журмыг шинэчлэн батлуулж гэрээний заалт, холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөн, зөрчил гаргалгүй ажиллаж байна. | 100% |
| 2.7. | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын www.erp.ulaanbaatar.mn, цахим хуудсыг байгууллагын үйл ажиллагаанд бүрэн ашиглах; | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Байгууллагын ажилчид өдөр тутмын үйл ажиллагаандаа www.erp.ulaanbaatar.mn, цахим хуудсыг тогтмол ашиглаж байна. | 100% |
| 2.8. | Хөдөлмөрийн аюулгүй байдалд хяналт тавих, аюулаас урьдчилан сэргийлэх, хөдөлмөр хамгааллын хувцас, ажлын хувцас хэрэгслээр хангана. | 12,500.0 | тоо | 2 | 2 | 2024 оны жилийн эцсийн байдлаар нормын хувцас буюу зуны хос хувцас-5, махны хувцас-5, улавч-4, гутал-3 хангаж, нийт 1,440,000.00 төгрөг зарцуулж ажилласан байна. | 100% |
| 2.9. | Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах; | - | Хуулийн хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн талаар нөлөөллийн 3 ажлыг ажилтнууддаа зохион байгуулсан. Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн 6 сургууль, 54 цэцэрлэгийн нярвуудад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн талаар сургалт зохион байгуулж ажилласан. | 100% |
| 2.10. | Ажилчдыг мэргэшүүлэх, мэдлэг боловсрол олгох сургалтад хамруулах; | 5,000.0 | Сургалтанд хамрагдсан тоо | 5 | 10 | 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах” тухай хуулийн шинэчилсэн найруулга, 02 дугаар сарын 15-ны өдөр “2023 онд үүссэн захирамжийн баримт бичгийг цахим хэлбэрт шилжүүлэх” тухай, 02 дугаар сарын 22-ны өдөр “Стресс менежмент”, 02 дугаар сарын 26-ны өдөр “Цахим орчныг ашиглан ажлын бүтээмжээ нэмэгдүүлэх”, 02 дугаар сарын 27-ны өдөр “Алсын хараа-2050”, 03 дугаар сарын 01-ний өдөр “Хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах талаар авах арга хэмжээний тухай УИХ-ын 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэгч төрийн байгууллагын зөвлөлдөх 3 дахь уулзалт, 03 дугаар сарын 12, 14-ний өдрүүдэд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | “Бодлогын баримт бичгийн төлөвлөлт, тайлагналт хяналт шинжилгээ, үнэлгээний аргазүй, 05 дугаар сарын 03-ны өдөр “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах тухай” хуулийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудал сэдэвт хэлэлцүүлэг, 05 дугаар сарын 10-ны өдөр Авлига, ашиг сонирхлын зөрчил, түүний хор хөнөөл, урьдчилан сэргийлэх арга зам, 05 дугаар сарын 14-ний өдөр “Монгол бичгээр баримт бичгийг зохион бүрдүүлэх”, 05 дугаар сарын 27, 28-ны өдрүүдэд төрийн албан хаагчийг чадавхижуулах нь “Хүний нөөцийн удирдлага” 10 дугаар сарын 29-ний өдөр нийслэл улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах иргэд нийгмийн суурь үйлчилгээг 20 минутын дотор авах шинэ орчинг бүрдүүлэх бодлогын хүрээнд ЗГ-аас баримтлах бодлого “20 минутын хот” 11 дүгээр сарын 14-ний өдөр “хяналт шинжилгээ үнэлгээ, байгууллагын хяналтын тогтолцоо, түүнийг хэрэгжүүлэхэд анхаарах зарим асуудал” 11 дүгээр сарын 21-ний өдөр төрийн албан хаагчийн ёсзүй, авлига ашиг сонирхолын зөрчлдөөс урьдчилан сэргийлэх” 12 дугаар сарын 03-ны өдөр “Худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах техникийн тодорхойлолт боловсруулах бэлтгэх” сургалт нийт 15 удаагийн сургалтад нийт давхардсан тоогоор 6 ажилтан хамрагдсан. Худалдан авах ажиллагааны А3 сургалтанд 2 ажилтан хамрагдаж сертифкат авсан. | |
| 2.11. | Сул ажлын байрны зарыг өөрийн цахим хуудаст тогтмол байршуулж, сонгон шалгаруулалтыг явуулж байх; | - | Сул ажлын байрыг зарласан тоо | 3 | 3 | 2024 оны жилийн эцсийн байдлаар Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу байгууллагын бүтэц орон тооны дутагдалтай 9 сул орон тоог байгууллагын цахим хуудас буюу www.bagachuudkhuns.ub.gov.mn-д мөн фэйсбүүк хуудсанд нийтэлж 9 ажилтныг хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу сонгон шалгаруулж ажилд авсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.12. | Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд хууль, зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлэх, хариуг албан ёсоор өгч хэвших, өргөдөл, гомдлын хугацаа, зөрчлийн үзүүлэлтийг бууруулах, шийдвэрлэлтийг сайжруулах, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж ажиллах | - | Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь | 100 | 100 | 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар иргэдээс ирүүлсэн гомдол мэдээлэл байхгүй. Нийслэлийн өргөдөл гомдлын цахим erp.ulaanbaatar.mn программаар ирсэн 17 өргөдлийг хүлээн авч ажилд орох 9, ажил хавсран гүйцэтгэх 2, ажлаас чөлөөлөх 4, ажил хавсран гүйцэтгэснийг болих 1 өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэсэн. | 100% |
| 2.13. | Байгууллагын албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангуулах | 8,500.0 | Тоо | 12 | 12 | Нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд ажилтнуудын цалинг нэмэгдүүлэх тухай зорилтод түвшинд тусгаж, Нийслэлийн өмчийн харилцааны газарт 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдөр хүргүүлж, 2024 оны зорилтод түвшин батлагдаж ажилчдын цалинг 20 хувиар нэмэгдүүлж ажилласан. Нийт ажилчдыг 2 удаагийн эрүүл мэндийн үзлэгт 2,192,000.00 төгрөгөөр хамруулж, 1,704,100.00 төгрөгөөр нэг удаагийн хамгаалах хэрэгсэл материалаар хангаж, тухай бүр нь ажилтныг ажиллах нөхцлөөр хангасан. Байгууллагын дотоод журамд заасны дагуу шинээр орон байранд орсон 2 ажилтанд нэг удаагийн буцалтгүй тусламж тус бүр 1,000,000.00 төгрөг, нийт 2,000,000.00 төгрөг, 1 ажилтанд нас барсны тэтгэмж 1,000,000.00 төгрөг, гэр хороололд амьдардаг 9 ажилчдад түлээ, нүүрсний хөнгөлөлтийг үзүүлж 2,888,000.00 төгрөгийг тус тус олгосон. Сар шинийн баярыг тохиолдуулан ахмад настнуудад хүндэтгэл үзүүлж, хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан ажилтнуудын хүүхдүүдийг хүлээн авч баярлуулсан. Нийт ажилтнууд удирдах дээд байгууллагаас болон бусад байгууллага, дотооддоо зохион байгуулсан 15 удаагийн сургалтанд хамрагдаж мэдлэгээ дээшлүүлсэн. | 100% |
| **Зорилго 3. Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1. | Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн төрийн өмчийн, сургууль цэцэрлэгүүдтэй “Бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ” байгуулна. | - | тоо | 85 | 86 | Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн төрийн өмчит нийт 73 цэцэрлэг, ерөнхий боловсролын 12 сургуультай бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулан, гэрээний дагуу чанар, стандартын шаардлагад нийцсэн 32 нэр төрлийн 119 бараа бүтээгдэхүүнээр тасралтгүй хангаН ажиллаж байна. | 100% |
| 3.2. | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа бүтээгдэхүүн худалдан авах тухай хуулийн дагуу шаардлагатай бараа, хүнсний бүтээгдэхүүнийг худалдан авах ажиллагааг зохион байгуулна. | 4,560,000.0 | Багцын тоо | 21 | 21 | 2024 оны худалдан авах төлөвлөгөөнд тусгасан 22 багц ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зарлаж, төрийн худалдан авах ажиллагааны цахим системд байршуулсан. Нээлттэй тендер шалшагруулалтын аргаар 22 багцад худалдан авах ажиллагааг зарлахад 17 багцад 12 аж ахуйн нэгж байгууллага тендерийн баримт бичиг ирүүлсэн бөгөөд 5 багцад огт тендерийн материал ирээгүй болно.<br>Үнэлгээ хийх явцад 7 багцад ирүүлсэн тендерийн баримт бичиг хянан, үнэлж үзээд 3 аж ахуйн нэгж байгууллагад гэрээ байгуулах эрх олгосон. Үүнээс 2 аж ахуй нэгж байгууллагатай 5 багцтай гэрээг байгуулан ажиллаж байгаа бөгөөд 1 аж ахуй нэгж нь тендерийн баримт бичигт заасны дагуу гэрээ байгуулах гүйцэтгэлийн баталгаа байршуулаагүй тул тус тендерийн баталгааг цуцалж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6.2-д заасны дагуу тендерийн баталгаа улсын орлого болгоно гэж заасан тул худалдан авах ажиллагааг дахин зохион байгуулах шийдвэр гаргасан. Нээлттэй тендер шалгаруулалтыг одоогийн байдлаар 5 удаа зарласан боловч шаардлагад нийцсэн тендерийн баримт бичиг ирүүлээгүй, нэг ч оролцогч оролцоогүй багцад дахин 6 дахь тендер шалгаруулалтыг зарлан 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр нээлтээ хийн үнэлгээ хийх шатанд явж байна. Түргэн гэмтэх бүтээгдэхүүн болох сүү сүүн | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүтээгдэхүүнийг худалдах худалдан авах гэрээний дагуу "Апу дейри" ХХК-аас шууд түгээлгэж, талх, талхан бүтээгдэхүүн, нарийн боовыг "Талх чихэр" ХХК, "Прайм пастри" ХХК-тай хийсэн гурвалсан гэрээний дагуу үйлдвэрээс шууд түгээлгэн, хөндлөнгийн хяналтыг хийн ажиллаж байна. | |
| 3.3. | Шалгарсан хуулийн этгээдтэй гэрээ байгуулан, шаардлагатай бараа, хүнсний бүтээгдэхүүнийг шинжилгээний бичиг, гарал үүслийн бичгийг үндэслэн татан авч, стандарт, шаардлагад нийцсэн агуулахад горимын дагуу хадгална. | - | Барааны нэр төрлийн тоо | 110 | 120 | "Эрдэнэ энх трейд" ХХК, "Хүрэмт халуун рашаан" ХХК Супер ирээдүй ХХК 3 аж ахуйн нэгж байгууллагад гэрээ байгуулах эрх олгосны дагуу агуулах болон бараа бүтээгдэхүүний нөөц, хадгалалт, хамгаалалтыг үзэх зорилготой 5 хүний бүрэлдэхүүнтэй баг 05 дугаар сарын 06-наас 15-ны өдрийн хооронд, 09 дүгээр сарын 02-ноос 05-ны өдрийн хооронд ажилласан. Тухайн бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын агуулах стандартын дагуу нөөц боломж сайтай байсан бөгөөд бүтээгдэхүүнийг шинжилгээний бичиг төмс хүнсний ногоо болон нарийн ногоо, цагаан будаа, хар чавганы шинжилгээний бичгийн аюулгүйн үзүүлэлт дутуу байсан тул албан бичиг хүргүүлэн шинжилгээний бичгийн аюулгүйн үзүүлэлт бүрэн ирүүлж зөрчлийг арилган гарал үүслийн бичиг шинжилгээний бичигт үндэслэн татан авч цэцэрлэг, сургуулиудад түгээн ажиллаж байна. | 100% |
| 3.4. | Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн төрийн өмчит цэцэрлэгүүдээс ирүүлсэн захиалгын дагуу бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас ирүүлсэн хүнсний бүтээгдэхүүнийг чанар, стандартын шаардлагад нийцсэн, шинжилгээнд бүрэн хамрагдсан, эрүүл, аюулгүй, баталгаатай байдлыг хангасан эсэхэд хяналт тавьж, зориулалтын тээврийн хэрэгслээр нийлүүлэх; | - | Нийлүүлсэн тоо | 80 | 100 | Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн төрийн өмчит цэцэрлэгүүдээс ирүүлсэн захиалгын дагуу бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас авч буй хүнсний бүтээгдэхүүнийг чанар, стандартын шаардлагад нийцсэн, шинжилгээнд аюулгүйн үзүүлэлт бүрэн хамрагдсан, эрүүл, аюулгүй, баталгаатай байдлыг хангасан эсэхэд хяналт тавьж, зориулалтын тээврийн хэрэгслээр хүнсний бүтээгдэхүүнийг хурдан шуурхай, чирэгдэлгүй нийлүүлж байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилго 4. Өмнөх оны төлөвлөгөөнөөс биелээгүй, цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ (2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилго 2-ын 2.2-ын төлөвлөсөн ажил бүрэн биелэгдээгүй тул дахин хэрэгжүүлэх)** | | | | | | | |
| 4.1. | Контор, агуулахын барилгын ашиглалт, элэгдэлийг бууруулах зорилгоор урсгал засвар хийнэ. | 19,500.0 | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | 2024 оны жилийн эцсийн байдлаар контор, агуулахын барилгын ашиглалт, элэгдэлийг бууруулах зорилгоор агуулахын шал болон тусгай зориулалтын махны агуулахын шалыг стандартын будгаар будаж, мөн дээврийн ажлын засаж сайжруулахад нийт 7,525.00 мянган төгрөгийн зардал гарган засан сайжруулж ажиллалаа. Байгууллагын хашаа, харуулын байрыг засаж сайжруулахад 1,200,000.00 төгрөг зурцуулсан. | 100% |
| **Зорилго 5. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.** | | | | | | | |
| 5.1. | Худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр явуулж, иргэд, олон нийтийн оролцоо, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналтыг сайжруулах. | - | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | 2024 оны худалдан авах төлөвлөгөөнд тусгасан 22 багц ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу нээлттэйгээр зарлаж, төрийн худалдан авах ажиллагааны цахим системд байршуулан ажиллаж байна. | 100% |
| 5.2. | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон шилэн дансны тухай хуульд заасан мэдээ, мэдээллийг хуулийн хугацаанд оруулж, хэрэгжилтийг хангаж ажиллана. | - | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Нийтийн мэдээллийн ил тод байлгах хуулийн хэрэгжилтийг хангаж, байгууллагын шилэн дансны хөтлөлтөд 2024 оны 1-ээс 11 дүгээр саруудын 5,000,000.00 төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого болон зарлагын гүйлгээ гарсан тухай бүрд нь холбогдох мэдээллийг хугацаанд нь оруулж тайлагнасан бөгөөд 2024 оны 12 дугаар сарын шилэн дансанд байрших мэдээлэл нь 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөр тасалбар болгон оруулдаг болно. | 100% |
| 5.3. | Байгууллагын цахим хуудсанд болон мэдээллийн самбарт байгууллагын санхүүгийн болон үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг тухай бүр байршуулан иргэд олон нийтэд ил тод мэдээлж ажиллах; | - | Мэдээллийн тоо | 12 | 12 | Байгууллагын цахим хаяг Bagachuudhuns.ub.gov.mn нийт 36 мэдээ, байгууллагын мэдээллийн самбарт санхүү, хүний нөөц, ажлын зар, дүрэм журам, сургалтын мэдээлэл, шинэ мэдээлэл, үйл явцыг тухай бүр нь оруулан ажиллаж байна. | 100% |
| 5.4. | Байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгааг | - | Судалгааны тоо | 4 | 4 | 2024 онд харилцагч 2 дүүргийн төрийн өмчит 50 цэцэрлэг, сургуулиас 4 удаа сэтгэл ханамжийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | улирал бүр хийж, түүний мөрөөр авах арга хэмжээг зохион байгуулах | | | | | судалгаа авч ажилласан. Судалгаанд оролцогчдын санал хүсэлтийг хүлээн авч, бараа бүтээгдэхүүний төрлийг нэмсэн. Мөн төрийн өмчит цэцэрлэгийн сургуулийн нярвууд болон, түгээлтийн багийн ажилчдад 2 удаагийн сургалт зохион байгуулсан. Бараа бүтээгдэхүүн буцаах гомдлыг хүлээн авч, нийлүүлэгч байгууллагад тухай бүр мэдэгдэн чанарыг сайжруулан ажиллаж байна. | |
| **Зорилго 6. Хотын хөгжлийн индексийн шалгуур үзүүлэлтийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд-Ханган нийлүүлдэг хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангаж, харилцагч цэцэрлэг, сургуулиудад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажиллана.** | | | | | | | |
| 6.1. | Хотын хөгжлийн индекс: 30 (Хүнсний хангамжийн чанар)<br>Арга хэмжээ: Нийлүүлж буй 119 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн түүхий эд бүрийг шинжилгээнд хамруулж ажиллана. Лабораторийн сорилтын тогтоосон цаг тухай бүрт нь хамруулж ажиллана. | - | I, II, IV улиралд шинжилгээнд хамруулсан бүтээгдэхүүний тоо | 0 | 3 | Тус байгууллага нь нийт 32 нэр төрлийн 119 бараа бүтээгдэхүүнийг аюулгүй үзүүлэлт бүрэн шинжилгээний бичигтэй хүнсний бүтээгдэхүүнийг цэцэрлэг, сургуулиудад нийлүүлдэг. Мах, махан бүтээгдэхүүнийг мал эмнэлгийн нэгдсэн системд нэвтэрч, гарал үүслийн бичгийг 7 хоног бүрээр, хүнсний ногооны гарал үүслийг авч цэцэрлэг, сургуулиудад хүргүүлж байна. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т “Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлт Монгол Улсын болон олон улс, бүс нутгийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн шаардлага хангасан байна” гэж заасны дагуу импортоор орж ирсэн хүнсний бүтээгдэхүүнийг импортын гэрчилгээ болон гаалийн мэдүүлгийг үндэслэн хүлээн авч байна. Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн төрийн өмчит сургууль цэцэрлэгүүдэд хүнсний бараа бүтээгдэхүүний шинжилгээний бичгийг цаг тухай бүрт нь хүргүүлэн ажиллаж байна. | 100% |
| 6.2. | Хотын хөгжлийн индекс: 52 (Хүнсний хангамжийн хүртээмж)<br>Арга хэмжээ: Цэцэрлэг, сургуулиудад хүнсний бүтээгдэхүүний татан авалт, хадгалалт хамгаалалт, түүний боловсруулалтад эрүүл ахуйн талаарх зөвлөн туслах үйлчилгээ, арга зүйн зөвлөгөөг очиж үзүүлнэ. | - | Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх цэцэрлэг, сургуулийн тоо | 0 | 14 | Чингэлтэй, Сүхбаатар дүүргүүдийн төрийн өмчит сургууль, цэцэрлэгүүдээс 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс хойш 20 санал, гомдол ирсэн. Тухайн санал гомдлыг хугацаанд нь шийдвэрлэж, нийлүүлэгч аж ахуй нэгжид шаардлага хүргүүлсэн. Багц 15 (компотны материал) нийлүүлж буй аж ахуй нэгж байгууллага нь шаардлагыг биелүүлэхгүй байсан учраас гэрээг цуцалж, тендер зарлаж багц 15 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Илэрсэн зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулах ажлыг зохион байгуулна. | | | | | (компотны материал)-д шалгарсан аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан ажиллаж байна. Гомдол гарсан бараа, бүтээгдэхүүн нийлүүлж буй аж ахуйн нэгж байгууллагуудад албан бичиг хүргүүлж, барааны чанарыг сайжруулан чанар, стандартад нийцсэн бараагаар хангаж ажиллаж байна. Мөн хуурай хүнсний 5 агуулахын 160 м.кв талбайг, махны хөргүүртэй агуулахын 55 м.кв талбайд цемент цутган тэгшилж, хүнсний агуулахын зориулалттай будгаар будуулан шинэчилж сайжруулан ажиллаж байна. | |

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ

2024 оны ..... сарын ..... өдөр

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ:

Х.НЯМБААТАР

ТАЙЛАГНАСАН:

БАГАЧУУД ХҮНС ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ

2024 оны 12 сарын 04 өдөр

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

Б.МӨНХНАСАН

УЛААНБААТАР ХОТ
"БАГАЧУУД ХҮНС"
ОРОН НУТГИЙН ӨМЧИТ
5056314